



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/448

Булган сум

### Г Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгох тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан "Хөрсний доройтлыг бууруулж, усыг зохистой ашиглах зорилгоор "Дан" байрны дулаан, цэвэр усны шугамын өргөтгөлийн 2-р шатны ажил (Хангал сум, Хялганат тосгон)"-ыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан "Сувдан элс" ХХК-тай 325,166,823 (гурван зуун хорин таван сая нэг зуун жаран зургаан мянга найман зуун хорин гурав) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3. Тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Хангал сумын Хялганат тосгоны Захирагч (П.Отгондаваа)-д үүрэг болгосугай.

4. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Сувдан элс" ХХК-ийн захирал (Б.Бат-Орших)-д даалгасугай.


5. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

6. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010812

Аймгийн Засаг даргын 2025 оны  
06 дугаар сарын 26-ны ний өдрийн  
А/НД Дугаар захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	5,646,238	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	5,646,238	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	2,823,119	Ү.Бямбасүрэн
4	Нормчлолын сан	508,161	Ү.Бямбасүрэн
5	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Э.Эрдэнэжаргал
6	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Ү.Бямбасүрэн Э.Эрдэнэжаргал
7	Гүйцэтгэлийн баталгаа	Төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувь	Э.Эрдэнэжаргал
8	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 49 хоног	Ү.Бямбасүрэн